

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

1.1. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

2019 оны 4 дүгээр сард аймгийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн 4 удаа хуралдав. Уг хуралдаанаар аймгийн удирдлагууд тус аймагт долоо хоногт болж өнгөрсөн үйл ажиллагаануудын талаар танилцуулж, хэлтэс, агентлагийн удирдлагуудын хэрэгжүүлсэн ажил, санал, хүсэлтийг сонсож, цаг үеийн асуудлаар нийт 16 үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулан ажиллав.

Энэ сард байгууллагад ирсэн Төрийн шагналаар шагнуулахаар тодорхойлсон хүмүүсийн материалыг хүлээн авч танилцан холбогдох дээд байгууллагад журмын дагуу уламжлав. Үүнд: Төрийн шагналаар шагнуулахаар тодорхойлсон Өлгий, Цэнгэл, Улаанхус сумдын иргэдийн материалыг хүлээн авч танилцан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар баталсан Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журмын дагуу баримт бичгийг хянан шалгаж, шаардлага хангасан иргэдийн материалыг холбогдох яаманд уламжлан ажилласан.

Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын 9-р багийн нутаг Цагааннуур тосгоны 2 иргэн тарваган тахлын шинж тэмдэг бүхий өвчнөөр өвчилсөн хэрэг гарсан. Тухайн иргэд нэг гэр бүлийн хүмүүс байсан бөгөөд нөхөр болох “Т” нь 4 дүгээр сарын 28-ний өдөр, эхнэр болох “Р” нь хүнд байдалтай аймгийн Нэгдсэн эмнэлэгт хүргэгдэн эрчимт эмчилгээ хийлгэж байгаад 5 дугаар сарын 1-ний өдөр нас барсан юм.

Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан аймгийн Онцгой комисс шуурхай арга хэмжээ авч, урьдчилан сэргийлэх үүднээс аймгийн Засаг даргын 319 тоот захирамжаар 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн 6 хоног Цагааннуур тосгон, Өлгий сум, аймгийн Нэгдсэн эмнэлэгт хорио цээрийн дэглэм тогтоож, орж гарах бүх хөдөлгөөнийг болон сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоогоод байна.

Мөн аймгийн Засаг даргын 2019 оны 04-р сарын 30-ны өдрийн А/318 дугаар захирамжаар аймаг, сумдын Онцгой комисс, орон нутгийн гамшгаас хамгаалах алба, ерөнхий болон тусгай мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг дөрөвдүгээр сарын 30-ны өдрийн 23:00 цагаас эхлэн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн ажиллуулж байна.

ХОЁР. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2.1. Эрүүл мэндийн чиглэлээр

Аймгийн Эрүүл мэндийн газраас гаргасан 2019 оны халдварт өвчний эрсдэлээс сэргийлэх, мэдээлэл сургалт, сурталчилгаа хийх удирдамжийн дагуу Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн, Шипагер өрхийн эрүүл мэндийн төвийн их эмч, Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, сургуулийн эмч нар хамтран Өлгий сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 10-12 дугаар ангийн нийт 120 хүүхдүүдийг А гепатит өвчнийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, “Хоолны хордлого”, “Гэдэсний халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх”, “А гепатит буюу шар өвчнөөс сэргийлэх”, “Угаарын хийн хордлогоос сэргийлэх”, “Гарын эрүүл ахуй”, “Амьсгалын замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх” чиглэлээр мэдээлэл өгч ажиллаа.

2019 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төв нь аймгийн Нэгдсэн эмнэлгийн сүрьеэгийн диспансертай хамтарч Раушан өрхийн эрүүл мэндийн төвд сүрьеэгийн тусламж үйлчилгээний чиглэлээр хэрэгжиж буй эрх зүйн актын хэрэгжилт, Засгийн газрын 11-р тогтоолоор батлагдсан “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэгт хяналт, үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн А/119 тоот тушаалаар Баян-Өлгий аймагт вакцин хадгалах мөсөн ханатай 2 хөргөгч хуваарилагдаж ирснийг хөргөгч нь эвдэрсэн Булган сумын Эрүүл мэндийн төв болон Мейрим өрхийн эрүүл мэндийн төвүүдэд гардуулан өгсөн.

“Пневмококкийн эсрэг 13 цэнт вакцин”, “Халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцин” гэсэн хоёр төрлийн вакциныг 2019 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс шинээр нэвтрүүлж, 2, 4, 5, 9 сартай хүүхдүүдийг дархлаажуулах бэлтгэл ажил хийгдэж байна. Үүнтэй холбогдуулан 2019 оны 3 дугаар сарын 19-ний өдөр аймгийн Эрүүл мэндийн газраас “Пневмококкийн эсрэг вакцин, халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцинуудыг дархлаажуулалтад нэвтрүүлэх сургалт”-ыг харьяа эрүүл мэндийн байгууллагуудын эмч, сувилагч, дархлаажуулалтын ажилтнуудыг чадваржуулах, вакцинтай холбоотой мэдээллээр хангах зорилгоор зохион байгуулсан ба сургалтад 3 сум дундын эмнэлэг, 11 сум, тосгон, 4 өрхийн эрүүл мэндийн төвүүд зэрэг анхан шатны 18 эрүүл мэндийн байгууллагуудын 72 эмч, сувилагч, дархлаажуулалтын ажилтан, аймгийн нэгдсэн эмнэлгийн 2 их эмч, Эрүүл мэндийн газрын 4 мэргэжилтэн, нийт 78 эмч, мэргэжилтэн оролцлоо.

Аймгийн Мейрим өрхийн эмнэлэгт гэрийн идэвхтэй эргэлтийг сайжруулах сургалт зохион байгуулсан.

“Авто ослоор алаг үрсээ алдсаар байх уу” сэдэвт өдөрлөг зохион байгуулах тухай Эрүүл мэндийн газрын даргын 360 тоот албан бичгийг харьяа эрүүл мэндийн 28 байгууллагад 4 дүгээр сарын 4-ний өдөр хүргүүлсэн. Орон нутгийн 11.00 цагаас эхлэн аймгийн төвд Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, аймгийн төвийн 4 өрхийн эрүүл мэндийн төв, Зоонозын өвчин судлалын төв, Сансар эмнэлэг зэрэг 20 эрүүл мэндийн байгууллагын 400-гаад эмч, мэргэжилтнүүд автомашин ихээр зорчдог замууд дээр зогсож автомашинтай жолооч нарт сурталчилгаа нөлөөллийн ажлыг хийсэн.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Сургалтын хяналтын тоо, зардал батлах” тухай А/121 тоот тушаалын дагуу аймгийн Нэгдсэн эмнэлгийн дотрын нэг эмч Зүрх судлалын төрөлжсөн нарийн мэргэжлийн сургалтад, Мэс заслын нэг эмч ЭХО-гийн 3 сарын мэргэжил дээшлүүлэх сургалтад, Булган сумын Эх барих эмэгтэйчүүдийн их эмч эмэгтэйчүүдийн ЭХО-гийн 3 сарын сургалтад төсвийн санхүүжилтээр 2019 оны 4 дүгээр сарын 8-наас сургалтад хамрагдаж байна.

Эрүүл мэндийн яамны дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооноос “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй” сэдэвт 2 багц цагийн сургалтыг 2019 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр аймагт зохион байгуулав. Уг сургалтад аймгийн 150 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдав.

Хүүхдийн өвчний цогц менежментийн талаарх мэдлэг чадварыг дээшлүүлэх, шинэ мэдээллээр хангах зорилгоор 4 дүгээр сарын 8-12-ны өдрүүдэд 5 хоногийн сургалтыг зохион байгуулж байна.

Бугат, Цагааннуур, Ногооннуур сумдын Эрүүл мэндийн төвүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдсэн.

Жирэмсний болон нярайн хяналтыг сайжруулах, аймгийн Нэгдсэн эмнэлгийн оношилгоо, багийн эмч нарын үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор Нэгдсэн эмнэлэг болон 6 сумд ажил сайжруулах 3 сарын хугацаатай аян зохион байгуулах үүрэг даалгаврыг хүргүүллээ.

Аймгийн Засаг даргын 2019 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн А/245 дугаар захирамжийн хүрээнд аймгийн хэмжээнд 4 дүгээр сарын 18-наас 5 дугаар сарын 18-ныг хүртэл “Эрүүл хүнс” сарын аян явагдах бөгөөд аяны нээлтийн арга хэмжээнд эрүүл мэндийн салбарын 50-иад эмч, албан хаагчид хүрэлцэн ирсэн ба ард иргэдэд “Эрүүл хүнс-Таны эрүүл мэндийн баталгаа” сэдэвт 100 ширхэг гарын авлага тарааж, эрүүл хүнс сонгож хэрэглэх талаар зөвлөгөө өгч ажилласан.

Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэх судалгаа аймгийн хэмжээнд явагдаж байгаа бөгөөд судалгаа авах Tobacco spotter программын талаар аймгийн төвийн Мейрим, Рауан, Шипагер гэсэн 3 Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, ажилчдад мэдээлэл өгч, зарим байгууллагуудын орчинд судалгаа хийж байна.

2018 оны 7 дугаар сард болсон үерийн усанд нэрвэгдсэн Өлгий сумын 2, 3, 12, 13 дугаар багийн нутаг дэвсгэрийн талбайн хөрсөнд 3 дахь удаагийн халдваргүйжүүлэлт хийж ажлын тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн.

ГУРАВ. ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

3.1. Цахилгаан хангамжийн талаар

Аймгийн хэмжээнд Баруун бүсийн эрчим хүчний системээс 13182.0 мян.кВ.цаг цахилгааныг худалдан авч, 11202.0 мян.кВ.цаг цахилгаан худалдан борлуулсан. Нийт 1980.0 мян.кВ.цаг цахилгааныг шугамд алдсан. Нийт алдагдал 15%-тай байгаа. Худалдан борлуулсан цахилгаанд 1439.0 сая төгрөгийн нэхэмжлэл бичиж, 1426.0 сая төгрөгийг цуглуулсан. Борлуулалтын орлого 99%-ийн цуглуулгатай байна.

3.2. Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ийн үйл ажиллагааны талаар

Тус байгууллага нь 2019 оны 4 дүгээр сард шуудангаар болон мэйл хаягаар компаниас 4, орон нутгийн бусад байгууллагаас 8, нийт 12 албан бичгийг хүлээн авч тухай бүр бүртгэл хөтлөн, байгууллагын удирдлагад танилцуулан холбогдох албан тушаалтнуудад шилжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Мөн газрын үйл ажиллагааны асуудлуудаар албан байгууллагад 5 албан бичиг боловсруулан хүргүүлж хариу, шийдвэр гаргуулж ажиллав.

Газрын орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангаж тайлант сард 9542,5 мянган төгрөгийн төлөвлөгөөтэй байсан ба 14350,3 мянган төгрөгийн нэхэмжлэх бичиж орлогын төлөвлөгөөг 150.38%-аар биелүүллээ.

Тухайн сард 65429,1 мянган төгрөг зарцуулах төлөвлөгөөтэй байснаас 57315,3 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, газрын үйл ажиллагааны зардлын төлөвлөгөөний биелэлт 87,6%-тай байна.

3.3. Усны талаар

Авлагатай аж ахуйн нэгж, байгууллагуудад мэдэгдэх хуудас тарааж, авлага цуглуулах арга хэмжээ авч ажилласан.

Усны даралт буурах үед урьдчилан сэргийлэх зорилгоор сосонк гаргаж, талбайг усан зөрчлийг арилгах талаар арга хэмжээ авч ажиллав.

Улаанбаатар хотод салбараас зохион байгуулсан 5 хоногийн нягтлан бодогчдыг чадавхжуулах сургалтад тус компаниас тооцооны ня-бог хамруулсан.

Тус аймагт “Тарваган тахал”-ын өвчин илэрсэнтэй холбогдуулан “СУАТ” ХХКомпаниас дараах урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч ажиллав. Үүнд:

- Нийт ажилчдад амны хаалт тарааж өгөв;
- Нийт ажилчдад “Тарваган тахал” өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж, зааварчилга өгөгдсөн;
- Төв байр болон цех салбаруудад ариутгалын бодисоор халдваргүйжүүлэлт хийлгэсэн болно.

3.4. Нисэх буудлын үйл ажиллагааны талаар

2019 оны 4 дүгээр сарын 1-нээс 30-ныг хүртэл нийт 19 агаарын хөлөг хүлээж авснаас “Хүннү-Эйр” ХХК-ийн 12 рейсийн агаарын хөлөгөнд 270 том хүн, хагас зардал 10, амь даатгал 19, ачаа 381 ш, гар тээш 274 ш, 33 ш шуудан, “Аэро монголиа” ХХК-ийн 7 рейсийн агаарын хөлөгөнд 262 том хүн, хагас зардал 14, амь даатгал 25, ачаа 349 ш, гар тээш 279 ш, 8 ширхэг шуудан тус тус тээвэрлэсэн байна. Тээвэрлэгч компаниудын ажилчид болон нисэх буудлын ажилчдыг 378 удаа, 172 ш гар тээшийг тус тус аюулгүй байдлын үзлэгт хамруулж, ямар нэгэн зөрчилгүй нислэгийн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллав.

Бүх тоног төхөөрөмжүүдэд үзлэг үйлчилгээ хийж ямар нэгэн сааталгүй ажилласан болно.

Цаг агаарын улмаас 2 удаагийн нислэг цуцлагдсан.

Автомашин шатахууны зарцуулалтын тооцоо, техник, тоног төхөөрөмжүүдийн ашиглалтад сар бүр хяналт тавьж ажиллаж байна.

Нисэх буудлын удирдах газраас ирсэн албан бичиг, судалгаануудад цаг тухайд нь хариу өгч, мэдээллээр хангаж ажиллаж байна.

ДОЛОО. СУМ, ОРОН НУТГИЙН ТАЛААР

1.ӨЛГИЙ СУМ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын ажлын талаар

Дөрөвдүгээр сард тус сумын Засаг даргаас нийт 26 захирамж гарч хэрэгжилтийг хангуулан ажиллав.

Ард иргэдээс 66 өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх шатандаа байна.

Иргэний бүртгэлээр энэ сард 555 хүнд үйлчилгээ үзүүлснээс:

- Төрөлт	109
- Гэрлэлт	25
- Нас баралт	18
- Гэр бүл цуцлалт	9
- Үрчлэлт	4
- Дахин олголт	0
- Цахим үнэмлэх олголт	166
- Шилжих хөдөлгөөн	
- Ирсэн	48
- Явсан	0

- Овог нэр, нэр өөрчлөлт 4
- Эцэг тогтоолт 0
- Иргэний шинэчилсэн бүртгэлд 172 иргэн тус тус хамрагдсан байна.

Хоёр. Захирагчийн ажлын алба, дэд бүтэц, худалдаа, үйлчилгээний талаар

Тухайн сард тамхи худалдахаар улсын тэмдэгтийн хураамж төлсөн нийт 9 ш хүнсний дэлгүүрт сумын Засаг даргын захирамж гаргаж, тусгай зөвшөөрөл олгосон.

Аймгийн Засаг даргын санаачилгаар зохион байгуулсан “Эрүүл хүнс” сарын аяны нээлтийн арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран аймгийн төвд талбайд зохион байгуулж, уг арга хэмжээнд худалдаа үйлчилгээний цэг салбаруудын төлөөлөл болох нийт 150 гаруй хүн хамрагдав.

“Тирлик” захын урьд талын авто замын дагуу төмс, хүнсний ногоо худалдаалж буй иргэдэд нийтийн эзэмшлийн зам талбайг чөлөөлөх талаар аймгийн Замын цагдаагийн газартай хамтран албан шаардлага хүргүүлж ажилласан.

Гурав. Хууль, эрх зүйн үйл ажиллагааны талаар

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Өлгий сумын ЗДТГазар хамтран Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг сарын аяныг зохион байгуулж, хуваарийн дагуу 2 удаа эргүүл постод гарч ард иргэдэд ухуулга сурталчилгаа хийж ажиллав.

Аймгийн 13 сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нар Өлгий сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагаатай танилцаж харилцан туршлага судлан, өөр өөрсдийн туршлагаас хуваалцан уулзалт ярилцлага зохион байгуулсан.

“Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт хэрхэн бэлтгэх арга зүй” сэдэвт 2 өдрийн сургалтад амжилттай оролцсон.

Дөрөв. Ариун цэвэр, хот тохижилтын талаар

Өлгий хотын гудамж, зам талбайн цэвэрлэгээг хийж 21 тн хогийг хогийн нэгдсэн цэгт хүргэв.

Төв талбай болон тээвэрчдийн гудамж, багуудын гэрэлтүүлгийн шугамуудын засвар үйлчилгээг хийж хотыг шөнийн гэрэлтүүлгээр ханган ажиллаж байна.

Гудамж, талбайн цэцгийн мандлуудын засвар үйлчилгээг хийж цэвэрлэн, шороог суллаж шарилжуудыг нь түүв.

Тус сумын нохой тэжээх, устгах журамд нэмэлт өөрчлөлт оруулан шинэчлэн боловсруулав.

Тав. Нийгмийн бодлогын талаар

Хүүхэд харах үйлчилгээ эрхэлдэг иргэдийн үйл ажиллагаатай танилцаж байнгын хяналт тавьж ажиллаж байна.

“Хоггүй Өлгий” 5 хоногийн ариун цэврийн ажлын хүрээнд Өлгий сумын багуудад ажиллаж айл өрхүүдэд ариун цэврийн шаардлага тавьж ажиллав.

Өлгий сумын Засаг даргад хүүхэд үрчлүүлэх талаар гаргасан 6 хүний өргөдлийн дагуу гэрт нь очиж дүгнэлт гарган, сумын Засаг даргын захирамжаар үрчлэлт хийлгэв.

Тус аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлд Өлгий сумын ЗДТГазрын төрийн албан хаагчдын зэрэг дэвийн судалгааг зохих маягтын дагуу гаргаж хүргүүлэв.

2. САГСАЙ СУМ

Нэг. Удирдлага, зохион байгуулалт, хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Сумын Соёлын төвд үзэгчдийн суудал нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан.

Сумын удирдлагуудаас аймгийн “Жол” ХХК-д хүсэлт явуулан Өлгий-Сагсай сумдын хоорондын авто замыг тэгшлүүлэв.

Сумын Засаг даргын Тамгын газрын даргын А/07 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах журам”-ын дагуу төрийн жинхэнэ албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинээр боловсруулж, холбогдох бичиг баримтын хамт аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлсэн.

Аймгийн хэмжээнд зохион явуулж байгаа “Эрүүл хүнс” сарын аяны хүрээнд аймгийн Эрүүл мэндийн газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг тус суманд хүрэлцэн ирж, аяны нээлтийн ажиллагааг зохион байгуулан байгууллагуудын гал тогоо болон хүнсний дэлгүүрүүдэд удирдамжийн дагуу хяналт-шалгалт хийлээ. Уг шалгалтад 4 байгууллага, 13 хүнсний дэлгүүр хамрагдав. Мөн хяналт-шалгалтаар илэрсэн зөрчлийн талаар зөвлөгөө өгч ажиллав.

Нотариатын үйлчилгээг 92 хүнд үзүүлж, тэмдэгтийн хураамжид 112,330.0 төгрөгийг оруулав.

Иргэдээс ирсэн 44 төрлийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, барагдуулах ажил зохион байгуулав. Байгууллагад ирсэн 58 бичгийг бүртгэж, түүний мөрөөр ажил зохион байгуулж, 35 албан бичгийг боловсруулан холбогдох газруудад хүргүүлэв.

Сумын иргэний бүртгэлд шинээр төрсөн 17, хүүхэд үрчилсний бүртгэлд 4, овог, эцэг /эх/-ийн нэр өөрчилсний бүртгэлд 2, эцэг тогтоосны бүртгэлд 1, гэрлэсний бүртгэлд 2, нас барсны 1, иргэний биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд 36, шилжин ирсэн 2, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд 3, газар өмчлөх бүртгэлд 4 иргэнийг тус тус бүртгэж, 42 иргэнд цахим үнэмлэх шинээр олгогдсон.

Хоёр. Төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Төсөвт байгууллагуудад ирсэн төсвийг зардлын зүйл ангиудад хуваарилан зарцуулж байна. Энэ сард нийт 240,562,900.0 төгрөгийн 153 төрлийн гүйлгээ хийгдсэн.

Татварын орлогод 8,819,300.0 төгрөгийг оруулан, 4 дүгээр сарын төлөвлөгөөг 306.8%-иар биелүүлэв.

Сум хөгжүүлэх санд 3,1 сая төгрөгийн зээлийг эргэн төлүүлсэн.

Гурав. Хөдөө аж ахуй, газар тариалан, мал эмнэлэг, байгаль орчны бодлогын хүрээнд

Газар тариалангийн салбарт 10-аас дээш жил ажилласан мэргэжилтэн, ажилчдын судалгааг гаргаж аймгийн ХХААГазарт хүргүүлсэн.

Хөрс боловсруулалт болон тариалалтад ажиллах техникийн байдлын мэдээг гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэв. Мөн хавар тариалах бэлэн үрийн мэдээг гаргаж аймгийн ХХААГазарт хүргүүлэв.

Тухайн сарын мал төллөлт, төл бойжилтын мэдээг гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн. Үүнд: Төллөсөн хээлтэгч ингэ 38, гүү 60, үнээ 875, хонь 34579, ямаа 21987. Хорогдсон төл нийт 1232, бойжсон төл нийт 56307 байна.

4 дүгээр сарын 15-наас 5 дугаар сарын 15-ны хооронд Мал эмнэлгийн ариун цэврийн сарын аяныг зохион явуулах талаар сумын Засаг даргын захирамжийг гаргуулан, уг арга хэмжээг зохион явуулах ажлын хэсгийг хавсралтаар батлуулсан. Одоогийн байдлаар 207 ш ямааны толгой, 28 бод, 56 бог малын сэг зэмийг устгаж ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн.

Мал эмнэлгийн ерөнхий газраас ирүүлсэн хүснэгтийн дагуу сүүлийн 20 жилийн халдварт, гоц халдварт, паразит, халдваргүй зэргийн судалгааг гаргаж хүргүүлсэн.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын төлөвлөгөөт шалгалтад 3 хувийн мал эмнэлгийн нэгж хамрагдаж, үйл ажиллагаанд нь хяналт-шалгалт хийсэн ба бага эрсдэлтэй гэсэн дүнтэй гарсан.

Дөрөв. Боловсрол соёл, шинжлэх ухааны талаар

“Заах аргач” мэргэжлийн зэргийн хугацаа нь дууссан 21 багшийн ажлыг хууль журмын дагуу шалгаж, мэргэжлийн зэргийн хугацааг нь сунгав.

“Эрүүл хүнс” сарын аяны хүрээнд тусгай төлөвлөгөө боловсруулан олон төрлийн ажлууд зохион явууллаа. Дотуур байрны гал тогооны хоолны цэс боловсруулан, технологийн картын дагуу хоол үйлдвэрлэлтэд байнга хяналт тавьж ажиллаж байна. Дэлхийн Зөн олон улсын байгууллагатай хамтран багш, ажилчдад “Хүнсний аюулгүй байдал, шошоглолтод тавих шаардлага” сэдэвт сургалт зохион явууллаа. Дотуур байрны гал тогоонд ашиглаж буй хүнсний бүтээгдэхүүнийг тогтмол шинжилгээнд хамруулан ажиллаж байна. Бүх ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрууллаа.

5 дугаар ангийн сурагчдаас улсын шалгалтад бэлтгэх зорилгоор математик, монгол хэлний хичээлүүдээс шалгалт авав.

29 хүүхдийг ЭЕШ-ын Монгол хэл бичгийн дахин шалгалтад тусгай хуваарийн дагуу бэлтгэж оруулав.

Аймгийн Засаг даргын А/245 дугаар захирамжийн дагуу тус суманд “Эрүүл хүнс” сарын аяныг зохион явуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн хүрэлцэн ирж 4 дүгээр сарын 22-нд аяны нээлтийг хийн төрийн болон төрийн бус байгууллагууд, дэлгүүрүүдэд хяналт-шалгалт хийсэн бөгөөд цэцэрлэгийн гал тогооны үйл ажиллагаа, хүнсний бүтээгдэхүүний хадгалалтад шалгалт хийж дүгнэлт гарган мэргэжил арга зүйн заавар, зөвлөмж өгч ажилласан.

Тав. Эрүүл мэнд, спортын талаар

Энэ сард 2 эх хөнгөрсөн. Эмнэлэгт 43 хүн 280 ор хоног хэвтэн эмчлүүлсэн. Вакцинжуулалтад 84 хүүхэд хамрагдсан ба одоогоор 113 жирэмсэн эх хяналтад байна. Хүүхдийн эндэгдэл 1 бүртгэгдсэн бөгөөд 33 удаа түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлж ажилласан.

Зургаа. Нийгмийн халамж, хамгаалал, хөдөлмөр эрхлэтийн талаар

Шинээр тэтгэвэр тогтоолгохоор материал ирүүлсэн 7 хүний өргөдлийг хүлээн авч танилцан барагдуулах ажил зохион байгуулсан.

НДСангаас олгох 4 дүгээр сарын өндөр настны тэтгэврийг 434 иргэнд 143,374,775 төгрөг, тахир дутуугийн тэтгэврийг 156 иргэнд 52,712,878 төгрөг, тэжээгч алдсаны тэтгэврийг 94 иргэнд 27,753,141 төгрөгийг тус тус олгосон.

Тэтгэмжийн сангаас жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг 10 хүнд 12,000,000 төгрөг, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг 1 хүнд 162,000 төгрөгийг олгосон.

НД-д шинээр сайн дураар даатгуулах 8 хүнтэй гэрээ байгуулсан.

3. ЦАГААННУУР ТОСГОН

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Удирдах ажилтны шуурхай хуралдааныг 3 удаа хуралдуулж, цаг үеийн болон төлөвлөгдсөн асуудлыг хэлэлцүүлэв.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/247 тоот захирамжаар тосгоны төвд 4 дүгээр сарын 24-ний өдөр цэрэг татлагын ажлыг зохион явуулав.

“Эрүүл хүнс” сарын аяны нээлтийн арга хэмжээг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэгтэй хамтран зохион байгуулж, аяны хүрээнд сургууль, цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн гал тогоо, үдийн цай, хүнсний хадгалалт хамгаалалтыг шалган зөвлөгөө өгөв.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор Захирагчийн албаны төрийн жинхэнэ алба хаагчдын Албан тушаалын тодорхойлолтыг журмын дагуу боловсруулан аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлэв.

Хоёр. Төсөв, санхүүгийн бодлогын талаар

1. Хилийн 0285-р анги	Үндсэн цалин	-	232,091,107.00 төгрөг
2. Дунд Сургууль	Үндсэн цалин	-	31,829,139.00 төгрөг
3. Хүүхдийн Цэцэрлэг	Үндсэн цалин	-	15,359,100.00 төгрөг
4. Эрүүл мэндийн төв	Үндсэн цалин	-	20,659,900.00 төгрөг
5. Соёлын төв	Үндсэн цалин	-	4,200,500.0 төгрөг
6. Зах.алба	Үндсэн цалин	-	10,076,800.00 төгрөг
Бүгд			314,242,546.00 төгрөг

Төсөвт байгууллагуудын өглөгүүд:

-Дунд сургууль	-	2,463,338 төгрөг
-Соёлын төв	-	713,479.0 төгрөг
-Хүүхдийн цэцэрлэг	-	747,417 төгрөг
-Захирагчийн алба	-	1,352,365 төгрөгийн өглөгүүд тус тус гарсан

байна.

Гурав. Статистик мэдээний талаар

Том малын зүй бус хорогдлын мэдээ:	- Төллөсөн хээлтэгч	- 9118
Үүнээс	- Гарсан төл	- 9118
	- Хорогдсон төл	- 293
	- Бойжсон төл	- 8825

Дөрөв. Эрүүл мэндийн талаар

Бүх үзлэг	-	421
-Урьдчилан сэргийлэх үзлэг	-	85
-Амбулаторийн үзлэг	-	131
-Гэрийн дуудлагын тоо	-	41
-Алсын дуудлага	-	15
-Нас баралт	-	1
-Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн	-	22
-Эмнэлгээс эмчлүүлж гарсан	-	27
-Аймагт төрсөн эх	-	3
-Өөрийн эмнэлэгт төрсөн	-	0
-Аймагт шилжүүлсэн жирэмсэн эх	-	3
-Хяналтад байгаа жирэмсэн эх	-	19
-Шинээр хяналтад авсан жирэмсэн эх	-	3
- Дархлаажуулалтад	-	21 иргэн тус тус хамрагдсан байна.